



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 741

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 149 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 55 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/587 дугаар захирамж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн болон Баян-Өлгий аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 2,529,854,196.90 (хоёр тэрбум таван зуун хорин есөн сая найман зуун тавин дөрвөн мянга нэг зуун ерэн зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132003094

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн  
141 дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН БОЛОН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,  
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк                                                                      | Балансын нийт үнэ<br>(төгрөг)                                                                                                                     | Санхүүжүүлсэн байгууллагын нэр                                                             | Шилжүүлэн авах<br>хуулийн этгээдийн нэр           |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------|
| 1   | Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний<br>хэлтсийн лабораторийн барилга<br>(18*12 м.кв, 3 давхар) | 2,489,199,199.00                                                                                                                                  | Улсын төсвийн хөрөнгө оруулалт<br>(Шүүх шинжилгээний ерөнхий газар)                        | Баян-Өлгий аймгийн<br>Шүүх шинжилгээний<br>хэлтэс |
| 2   | Тоёото ланкруйзер-80, 44-04 БӨТ                                                                 | 14,874,999.90                                                                                                                                     | Баян-Өлгий аймгийн ИТХ-ын 2023<br>оны 3 дугаар сарын 23-ны 149 дүгээр<br>тогтоол           | Шүүх шинжилгээний<br>ерөнхий газар                |
| 3   | Хюьндай каунтри, 22-96 УБН /автобус/                                                            | 12,889,999.00                                                                                                                                     | Нийслэлийн Засаг даргын 2024 оны<br>05 дугаар сарын 21-ний өдрийн А/587<br>дугаар захирамж |                                                   |
| 4   | Хюьндай каунтри, 80-52 УБН /автобус/                                                            | 12,889,999.00                                                                                                                                     |                                                                                            |                                                   |
|     | Нийт дүн                                                                                        | 2,529,854,196.90<br>(хоёр тэрбум таван<br>зуун хорин есөн сая<br>найман зуун тавин<br>дөрвөн мянга нэг<br>зуун ерэн зургаан<br>төгрөг ерэн мөнгө) |                                                                                            |                                                   |